



СЭЛЭНГЭ АЙМАГ
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/128

Алтанбулаг

Хөдөлгөөн хязгаарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7¹ дүгээр зүйлийн 7¹.1, Сумын Онцгой комиссын 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 8 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар Коронавируст (Ковид-19)-ын халдварын 3 тохиолдол нэмж бүртгэгдсэнтэй холбогдуулан 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 10:00 цагаас 06 дугаар сарын 18-ны 06:00 цаг хүртэлх хугацаанд сумын орох, гарах тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр хязгаарласугай.


2.Тандалт судалгааны ажил хийгдэж байгаа тул иргэд хүнсний дэлгүүр, ус түгээгүүрийн газар, эмийн сан орохоос бусад тохиолдолд гэрээсээ гарахгүй байхыг анхааруулж хяналт тавьж ажиллахыг 1,2,3 дугаар багийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа амралтын газрын үйл ажиллагааг 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 10:00 цагаас 06 дугаар сарын 18-ны 06:00 цаг хүртэлх хугацаанд түр хязгаарлаж, ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх ажил зохион байгуулахыг Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн (Б.Одмаа)-д даалгасугай.

4.Хөдөлгөөн хязгаарласан хугацаанд сумын хэмжээнд архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг хориглож, хяналт тавьж ажиллахыг Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн (Б.Одмаа)-д даалгасугай.

5.Замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгсэл, иргэдийн зорчих хөдөлгөөнд тавих хяналтыг тогтмолжуулах, халдвартай бүс нутгаас ирсэн тусгаарлалтад байгаа болон гарч байгаа иргэдэд хатуу хяналт тавьж ажиллахыг Шуурхай штабын орлогч дарга (Д.Амартүвшин)-д үүрэг болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хязгаарлалтын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тухай бүр танилцуулж ажиллахыг Шуурхай штабын дарга (Ү.Янжиндулам)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Н.ОТГОНЦОГТ

